



ЗАВХАН АЙМАГ ДАХЬТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР Ч.БЯМБАСҮРЭН
АУДИТОР Б.ЖАЛБАА

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Г.ХАШЦЭЦЭГ

Уг тайланг WWW.AUDIT.MN сайтаас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70463783, 70463612 дугаарын утсаар харилцана уу

ХАЯГ: Завхан аймаг дахь төрийн аудитын газар
Улиастай сум Жинст баг Нутгийн удирдлагын ордон
309 тоот

ОНХС, СХС-ИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

/Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүд нь урсгал зардлын шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь сангийн үйл ажиллагааны зорилго, зорилтод нөлөөлж байна/


 АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	
Аудитын зорилт, хамарсан хүрээ, аргазүй, шалгуур үзүүлэлт.....	1
Бүлэг 1.Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг болон эх үүсвэрийг холбогдох хууль журамд нийцүүлэн төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан боловч төсөл, хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө хууль, журмын зарим заалтуудад нийцүүлээгүй байна.....	4
<i>1.1Аймаг, сумын ОНХС нь хуульд заасан эх үүсвэрүүдээр орлогыг төлөвлөсөн байна.....</i>	<i>4</i>
<i>1.2Улиастай, Тосонцэнгэл, Дөрвөлжин сумд нь ОНХС-ийн хөрөнгийг сумын удирдлагыг хэрэгжүүлэх зардалд зарцуулжээ.....</i>	<i>8</i>
<i>1.3 Аймаг, сумдын ОНХС- аар хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр арга хэмжээнд тавих хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх болон тайлагнах үйл ажиллагаа хийгдэхгүй байна.....</i>	<i>14</i>
<i>1.4 Төсвийн тухай хуулийг шинэчлэн найруулсантай холбоотой бусад журам, зааварт өөрчлөлт хийх шаардлагатай байна.....</i>	<i>15</i>
БҮЛЭГ 2. СХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлжурамд заасан эрх үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.....	15
<i>2.1 Сум хөгжүүлэх сангийн дансанд бусад хөрөнгө байршуулсан байна.....</i>	<i>15</i>
<i>2.2 Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн мэдлэг чадвар дутмаг байна.....</i>	<i>17</i>
<i>2.3 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байна.....</i>	<i>21</i>
<i>2.4 Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зорилго, зорилт алдагдах эрсдэл бий болсон байна.....</i>	<i>23</i>
БҮЛЭГ 3. Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийн талаар.....	23
<i>3.1 ОНХС-ийн өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 85%- тай байна.....</i>	<i>23</i>

3.2 СХС-ийн өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 68,8 хувьтай байна.....	24
Дүгнэлт	25
Холбогдох байгууллагын санал	26
Зөвлөмж:	
<i>ТЕЗ-д өгсөн зөвлөмж</i>	27
<i>Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст өгсөн зөвлөмж</i>	28
<i>Сумдын засаг дарга нарт өгсөн зөвлөмж</i>	29

Товчилсон үгийн тайлбар:

ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ОНХНС	Орон Нутгийн Хөгжлийн Нэгдсэн Сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
МУ	Монгол Улс
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БИНХ	Багийн Иргэдийн Нийтийн Хурал
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НАНБХАСЗАСЗУСТ	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
ШХА	Шууд худалдан авах
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
СХС	Сум хөгжүүлэх сан
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл бүрэн эрх:

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 03 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/125 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг ҮАГ тайлагнахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх
2. Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх
3. Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад ОНХНС, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2017 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, мөн сум хөгжүүлэх сангийн орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, хяналт, тайлагналыг аймаг, сумын ИТХ, ЗДТГ, багийн Засаг дарга, ИНХ-ыг хамруулан шалгалаа.

Үндсэн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг зорилго:

ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангасны үндсэн дээр иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

СХС-ийн зорилго нь сумдад жижиг дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулагддаг.

Үндсэн мэдээлэл:

МУ-ын 2017 оны Төсвийн тухай хуульд ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг 1.708,7 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр сумдад 600.2 сая төгрөг, аймгийн ОНХС-д 743.9 сая төгрөг, орон нутгийн суурь зарлагад 432.5 сая төгрөг тус тус хуваарилжээ.

Сум хөгжүүлэх сан нь 2017 оны байдлаар нийт 5,966.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж байна.СХС-ийн зээлийг олгож эхэлснээс хойш /2011-2017 онуудад/ нийт 2892 иргэнд 10,373.0 сая төгрөгийн зээл олгожээ.

2017 оны жилийн эцсийн байдлаар 5,055.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байна. Үүнээс хэвийн төлөлттэй 2,332.1 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 2,493.7 сая төгрөг, төлөгдөх найдваргүй буюу чанаргүй 229.9 сая төгрөгийн зээл байна.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам,ҮАГ-ын төлөвлөгөө хөтөлбөрт үндэслэн дэд хөтөлбөр боловсруулан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх,асуулга лавлагаа болон судалгаа авах,орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын нөхцөл байдал,үр дүнд шинжилгээ хийх, шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг шалгах, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, бодит байдал дээр оршин байгааг үзэх, харьцуулах, нэгтгэх зэрэг аудитын горимын дагуу аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллаа.

Аудит хийж буй асуудлыг нэгтгэж тайланд тусгахдаа дараах арга зүйг ашиглаж баримтжууллаа.

- ✓ ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахдаа сум дүүргийн хөгжлийн индексийг үнэн зөв тооцсон эсэх
- ✓ БИНХ-ын тэмдэглэл, иргэдийн санал асуулгын хуудас хурлын шийдвэртэй нийцсэн эсэх
- ✓ БИНХ-аас гарсан шийдвэр тухайн шатны ЗДТГ, ИТХ-ын шийдвэртэй нийцэж байгаа эсэх
- ✓ Тухайн шатны ЗДТГ, ИТХ-ийн шийдвэр нь орон нутгийн хөгжлийн бодлого,ОНХС-ийн журамтай нийцэж байгаа эсэх
- ✓ Худалдан авах үйл ажиллагааг хологдох хууль,журмын дагуу зохион байгуулсан эсэх
- ✓ ОНХС-ийн дансны хуулга ажлын санхүүжилтийн хуваарь гэрээний дүнтэй тохирч байгаа эсэх
- ✓ Төсөл арга хэмжээний гэрээг батлагдсан загварын дагуу байгуулсан эсэх
- ✓ Сангийн хөрөнгийг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан журамд тусгагдсан чиг үүргийн дагуу зарцуулсан эсэх
- ✓ ТЭЗҮ нь бодит гүйцэтгэлтэй нийцэж байгаа эсэх
- ✓ Гэрээний хугацаанд хийгдээгүй ажлуудад алданги тооцож, хяналт тавьж ажилласан эсэх
- ✓ Төсөл арга хэмжээнд заасан ажлыг газар дээр нь очин үзэж, зураг төсөвтэй харьцуулан судалж, зураг авалт ажиглалт хийсэн
- ✓ Хөрөнгө оруулалтын ажлыг ашиглалтад хүлээн авсан комиссын актыг бодит байдалтай тулган, данс бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулсан
- ✓ Иргэдээс санал асуулга авсан
- ✓ Өмнөх аудитаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилтийг тулган шалгасан
- ✓ СХС-ийн аудитыг гүйцэтгэхдээ 2011-2017 оныг хамруулан тухайн онд зээлд хамрагдсан иргэдийн зээлийн эргэн төлөлтийг хүн бүрээр нь тулган баталгаажуулсан
- ✓ Зээлд хамрагдсан иргэд болон сумдын удирдлагуудтай уулзалт, ярилцлага хийж санал бодлыг тайланд тусган ажиллаа.

Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Аудит дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- 2017 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТ хууль
- НАНБХАСЗАСЗУСТ хууль
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол / ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал
- Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол / Босго үнэ батлах тухай
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал / Заавар батлах тухай/
- Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаал /Журам шинэчлэн батлах тухай
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал /Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам/
- Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “ Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”
- Төлбөрийн акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаал / төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам/
- ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоол батлагдсан “ СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Л.Уламбаяр удирдаж, аудитын менежер Г.Хашцэцэг үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Ч.Бямбасүрэн, аудитор Б.Жалбаа нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа:

Аудитыг 2018 оны 09 дүгээр сарын 15-нд эхэлж, 11 дүгээр сарын 30-ны дотор хийж гүйцэтгэн, аудитын тайлан, судалгааг ҮАГ-ын нийцлийн аудитын газарт хүргүүлсэн.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж, албан шаардлага, акт болон тайлангийн хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөх бүхий л шаардагдах нотлох зүйлс, мэдээллийг оруулсан болно.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлага, хамт олон, холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.


БҮЛЭГ 1. Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг болон эх үүсвэрийг холбогдох хууль журамд нийцүүлэн төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан боловч төсөл, хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө хууль, журмын зарим заалтуудад нийцүүлээгүй байна.

1.1 Аймаг, сумын ОНХС нь хуульд заасан эх үүсвэрүүдээр орлогыг төлөвлөсөн байна.

Сангийн яамнаас ОНХС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн тооцооллыг хийж төлөвлөдөг учир орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу хийж байгаа эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

2017 онд Сангийн яамнаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн эх үүсвэрийг анх 1,996.3 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд бүтцийг графикаар харуулбал:

График № 1



Графикаас харахад ОНХСнь Төсвийн тухай хуулийн 59.1.1, 59.1.2, 59.1.3, 59.1.5¹ дүгээр зүйлд заасан эх үүсвэрүүдээс бүрдсэн байна.

Аймгийн ОНХС-аас сумдын орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг төлөвлөхдөө батлагдсан аргачлалын дагуу тооцсон байна.

Аймгийн ОНХС-д орон нутгийн хөгжлийн Нэгдсэн сан болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгийг төсвийн хүндэрлээс шалтгаалан анх батлагдсан төлөвлөгөөг 287.6 сая төгрөгөөр бууруулан 1,708.7 сая төгрөгөөр баталж, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд тусгажээ.

Харин Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг тооцохдоо дараах үзүүлэлтийг харгалзсан байна. Үүнд:

- А. Сумын хүн амын индекс
- Б. Нутаг дэвсгэрийн хэмжээ

В. Алслалтын хэмжээ индекс

- Тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь
- АМНАТ-ийн 33 хувь

Жишээ нь: Хүснэгт № 1

/сая.төг/

Сумын нэр	Хүн амын тооноос хамааруулан олгох дүн	Газар нутгаас хамаарсан дүн	Алслалтаас хамаарсан дүн	Хүн амын нягтралаас хамаарсан дүн	Тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь	АМНАТ-ийн 33 хувь	НИЙТ ДҮН
Алдархаан	5.5	5.9	0.7	3.1	6.3		21.5
Асгат	1.9	0.5	5.3	1.0			8.9
Улиастай	32.1			3.1			35.2
Тосонцэнгэл	17.6	2.2	3.9	3.6			27.3
.....	141.5	67.9	84.9	59.42	129.8	41.3	524.8

Хүснэгтээс харахад Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-ийн орлогын шилжүүлгийг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 59.3² дахь заалтад заасан итгэлцүүрийг үндэслэн тогтоосон байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн **70 хувь** буюу **1,039.0** сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн санд, **30 хувь** буюу **524.8** сая төгрөгийг сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилахаар төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2³ дахь заалттай нийцэж байна.

Аймгийн ОНХС-ийн төлөвлөсөн эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 2

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэр	Дүн /сая.төг/
ОНХС-аас олгох орлогын шилжүүлгээр	1,996.3
Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон эх үүсвэрээс	0
Бусад эх үүсвэрээс / өмнөх оны үлдэгдлээс	0
ОНХС-ийн нийт эх үүсвэр	1,996.3
Үүнээс: Сумдад /30 хувь/	524.8
Аймгийн ОНХС-д /70 хувь/	1039.0

Аймаг, сумын ОНХС нь хуульд заасан эх үүсвэрүүдээр орлогыг төлөвлөсөн байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ийн 6.1⁴-д орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг
- Аймаг, сумдын үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр
- Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив тусламжаас бүрдэнэ гэж тусгасан байна.

Гэтэл 2016 оны 09 сарын 09-ний өдрийн Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар 56.2⁵, 59.1.4⁶ дэх заалтуудад өөрчлөлт орсонтой холбогдуулан үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсгийг төлөвлөх боломжгүй байна.

Тайлант онд татварын хувь хэмжээг өөрчилсөн тухай Аймагийн ИТХ-аас баталсан шийдвэр гараагүй тул татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон эх үүсвэрийг төлөвлөөгүй.

Мөн зарлагыг хэмнэх замаар бий болсон эх үүсвэр болон орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив, тусламжийг урьдчилан тооцож төлөвлөх боломжгүй учир ОНХС-ийн эх үүсвэрийг орлогын шилжүүлгээр төлөвлөсөн байна.

Аймаг, сумын ОНХС-нь хууль, журмын дагуу эх үүсвэрүүдийг бүрдүүлэн ажилласан байна.

Тайлант онд Аймагийн орон нутгийн санд нийт 3.993,1 сая төгрөгийн орлого төвлөрч, 3.829,1 сая төгрөгийн төсөвтэй төсөл хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэн 164.0 сая төгрөгийн оны эцсийн үлдэгдэлтэй ажиллажээ.

АОНХС нь дараах эх үүсвэрээс бүрдсэн байна.

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгээр 1,611.6 сая төгрөг
- ОНХС-аас сумдад шууд хуваарилсан 97.1 сая төгрөг
- Орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас 345.6 сая төгрөг
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон гадаад, дотоодын хандив тусламжийн орлогоор 5.0 сая төгрөг
- Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэрээр 425.6 сая төгрөг
- Хуульд заасан бусад эх үүсвэрээр 692.2 сая төгрөг
- Урьд оны үлдэгдлээс 816.0 сая төгрөг байна.

Дээрх эх үүсвэрүүдээс харахад АОНХС нь Төсвийн тухай хуулийн 60.2⁷-т заасны дагуу орлогын эх үүсвэрийг бүрдүүлэн ажиллажээ.

Аймаг, сумдын ОНХС-нд төвлөрсөн эх үүсвэрийг задалбал:

д/д	Сумдын нэр	Сумдын ОНХС-д орсон орлого	Үүнээс					Эхний үлдэгдэл	Зарлага	Эцсийн үлдэгдэл
			АОНХС-аас	Үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг	Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэрээс	Хандив, тусламж болон бусад	Бусад			
1	Алдархаан	17.8	17.8					55.0	62.2	10.6
2	Асгат	7.4	7.4					0.0	6.4	1.0
3	Баянтэс	18.3	11.9	1.4			5.0	0.0	18.3	0.0
4	Баянхайрхан	12.6	11.6				1.0	4.5	14.5	2.6
5	дөрвөлжин	118.6	118.6					0.0	118.6	0.0
6	Завханмандал	20.3	20.3					23.1	35.0	8.4
7	Идэр	56.1	29.2		4.9		22.0	171.1	225.2	2.0
8	Их-Уул	19.3	19.3	5.0			12.5	0	36.8	0
9	Нөмрөг	10.1	10.1					0	10.1	0
10	Отгон	42.7	36.7	2.0	4.0			54.9	79.4	18.2
11	Түдэвтэй	29.5	9.5				20.0	2.7	30.0	2.2
12	Сантмаргац	30.3	15.6	14.0	0.7			7.8	33.0	5.1
13	Улиастай	509.4	29.2	29.8	396.0		54.4	150.6	659.2	0.8
14	Тосонцэнгэл	68.6	22.6	28.7			17.3	33.9	80.0	22.5
15	Сонгино	14.3	11.3				3.0	42.1	46.0	10.4
16	Тэс	83.0	43.0		20.0		20.0	0.9	82.6	1.3
17	Тэлмэн	24.5	17.0	2.5		5.0		0.0	22.0	2.5
18	Ургамал	19.3	17.3				2.0	36.9	48.9	7.3
19	Цагаанхайрхан	34.3	8.0	5.8			20.5	12.3	34.9	11.7
20	Цагаанчулуут	18.6	8.6				10.0	5.0	20.8	2.8
21	Цэцэн-Уул	13.9	11.1				2.8	3.2	13.8	3.3
22	Шилүүстэй	26.1	9.4	13.7			3.0	0.0	21.2	4.9
23	Эрдэнэхайрхан	35.7	33.4				2.3	12.7	41.7	6.7
24	Яруу	13.4	13.4					0.0	13.4	0.0
	Сумдын дүн	1261.6	532.3	102.9	425.6	5.0	195.8	616.7	1754.0	124.3
25	Аймгийн ОНХС	1483.0	743.9	242.7			496.4	199.3	1642.6	39.7
26	Хот тохижилт, мал эмнэлэг	432.5	432.5					0.0	432.5	0.0
	Нийт дүн	3177.1	1708.7	345.6	425.6	5.0	692.2	816.0	3829.1	164.0

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа холбогдох хууль журмыг баримталсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Аймгийн орон нутгийн хөгжлийн санд анх 1,996.3 сая төгрөгийг олгохоор батлагдсан боловч Сангийн яамнаас төсвийн төсөлд тодотгол хийж, ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 287.6 сая төгрөгөөр бууруулан 1,708.7 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын орон нутгийн хөгжлийн санд орлогын шилжүүлгээс 435,3 сая төгрөгийг олгосон нь санхүүжилтийн 39.1 хувийг эзэлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 59.2.2 /энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах/ гэсэн заалттай нийцэж байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгосон байна.

Тайлант онд АОНХС-аас орлогын шилжүүлгийн 435.3 сая төгрөгийг сумдын ОНХС-д батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн олгожээ.

Сумдын ОНХС-ийн хөрөнгийг 2017 оны 06 сарын 09-ний өдрийн Аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор урьд оны үлдэгдлээс 6 сумд 102.0 сая төгрөгийг, 2017 оны 12 сарын 04-ний өдрийн хуралдааны тогтоолоор 8 сумд 63.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэмж олгохоор төсвийг тус тус тодотгосны дагуу сумдад нийт 600.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг нэмж тодотгосон шалтгаан нь сангийн яамнаас төсвийг бууруулан тодотгосон учир сумдын хэрэгжсэн төсөл, хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийг олгож чадахгүй, төсөвт өр үүссэнтэй холбоотой байна.

Үүнээс гадна Сангийн яамнаас 2017 онд Тогтвортой-амжиргаа-3 төслийн хүрээнд 24 сумыг хамруулан орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хяналт хийж үр дүнтэй зарцуулсан Дөрвөлжин, Идэр,Тэс,Отгон сумдад 97.1 сая төгрөгийг урамшуулалд олгосон байна.

Дээрх урамшууллыг АОНХС-нд олгох шилжүүлэгт оролцуулан тооцсоноос АОНХС-ийн орлогын шилжүүлэг дутуу олгогдсон байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийг төлөвлөхдөө ТЭЗҮ, зураг төсөв батлагдсан,тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээг төлөвлөдөггүй дутагдал байна.

1.2 Улиастай, Тосонцэнгэл, Дөрвөлжин сумд ОНХС-ийн хөрөнгийг сумын удирдлагыг хэрэгжүүлэх зардалд зарцуулжээ.

АОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлууд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан ч, зарим сумдын хувьд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил нь үндсэн чиглэлд тусгагдаагүй байна.

Аймгийн ОНХС-аар 23 төрлийн төсөл, хөтөлбөр арга хэмжээнд 988.3 сая төгрөгийг, сумдын ОНХС-аар 190 төрлийн төсөл хөтөлбөр арга хэмжээнд 1,651.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

АОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний чиг үүргийг төлөвлөгөө, гүйцэтгэлээр графикаар харуулбал:

График № 2



Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2017 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулсан хэдий ч хэрэгжүүлэхдээ ИТХ-аар батлуулсан арга хэмжээний жагсаалтыг мөрдөн ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 60.3 дахь заалт болон Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.2²-т заасан заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ, төслийн жагсаалтад ороогүй боловч, үндсэн чиглэлд тусгагдсан дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлжээ.



➤ Багийн эмч нарт мотоцикль худалдан авсан 27.2 сая төгрөг

➤ Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийхэд 164.8 сая төгрөгийн өртөгтэй ажил /2017 онд 80.0 сая төгрөг олгосон/

➤ Нэгдсэн эмнэлгийн унтуулгын аппарат худалдан авахад 45.0 сая төгрөгийн ажил /2017 онд 30,0 сая төгрөг олгосон/

- Алаг уулын Жи-мобайль станцын барилга барих ажилд 63.7 сая төгрөг
- Цэнгэлдэх хотхоны цахилгааны шугам хийх ажилд 16.0 сая төгрөг
- Хилийн цэргийн 0277-р ангийн барилга барих цементний үнэд 10.0 сая төгрөг зарцуулсан
- Стандарт хэмжил зүйн төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 10.4 сая төгрөгийг тус тус санхүүжүүлжээ.

Сумдын хувьд дараах 4 сум хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөнд 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй ажлыг төлөвлөжээ.

- Идэр сумын ОНХС-аар хийгдсэн Эрүүл мэндийн төвийн өвчтөний ор нийлүүлэх 3.2 сая төгрөгийн ажил
- Улиастай сумын Цагдаагийн газрын цайны газарт тоног төхөөрөмж худалдан авах 9.9 сая төгрөгийн, эмнэлгийн ор нийлүүлэх 3.0 сая төгрөгийн, орон нутаг дахь хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийх 2.0 сая төгрөгийн,
- Прокурорын байгууллагад ажлын хувцас нийлүүлэхэд 0,8 сая төгрөгийн, нутгийн зөвлөлийн гишүүдэд хүндэтгэл үзүүлэхэд 2.5 сая төгрөгийн
- Тосонцэнгэл сумын мэс заслын тасгийн засварын 10.0 сая төгрөгийн, Нутгийн удирдлагын ордны засварын 10.0 сая төгрөгийн
- Шилүүстэй, Эрдэнэхайрхан сумдын эрүүл мэндийн төвд ор нийлүүлэх ажлын 5.0 сая төгрөгийн ажлууд үндсэн чиглэлд тусгагдаагүй байна.



Дээрх зөрчил нь сумдад олгогдсон санхүүжилтийн 7.7%-ийг эзэлж байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох дүрэм журмыг баримталсан боловч, иргэдийн ОНХС-ийн талаарх ойлголт хангалтгүй байна.

Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2017 оны ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр болон 2017 оны үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулж, жагсаалтыг иргэний нийгмийн бүлэг болон, иргэдийн төлөөлөлд танилцуулан нээлттэй хэлэлцүүлэн баталгаажуулсан нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан журмын 6 дугаар зүйлтэй нийцсэн байна.

Харин сумдын хувьд төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн иргэдийн саналыг батлагдсан маягтын дагуу авч нэгтгэн багийн иргэдийн нийтийн хурлаараа хэлэлцүүлэн хамгийн олон санал авсан, төсөл хөтөлбөрийн урьдчилсан жагсаалтыг боловсруулсан боловч багийн иргэдийг санал асуулгад бүрэн хамруулах асуудал сум бүрт харилцан адилгүй байна.

Аудитын явцад 8 сумын 160 иргэнээс ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалтын талаар санал асуулга авч нэгтгэсэн бөгөөд ОНХС-д иргэдийн оролцооны талаар дараах байдлаар хариулсан байна.

График № 3






График № 4

Таны сумын Засаг дарга ОНХС-аас хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авсан уу?



Графикаас харахад мэдээлэл авдаггүй буюу мэдэхгүй саналууд дийлэнх хувийг эзэлж байна.

Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг эрэмбэлэх үйл ажиллагаа журмын хүрээнд хийгдээгүй байна.

Аймгийн ОНХС-аар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг эрэмбэлэхдээ хамгийн олон санал болон орон нутгийн хөгжилд тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

2017 оны Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг Аймгийн ИТХ-ын хурлын хуралдааны 2016 оны өдрийн 12 дугаар сарын 02-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор баталжээ.

Сумдын ОНХС-ийн хувьд багийн ИНХ-аас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээг хамгийн олон санал авснаар нь эрэмбэлж, жагсаалтыг сумын Засаг даргад хүргүүлсэн боловч, сумын ЗДТГ нь нэгдсэн жагсаалт бэлтгэхдээ хөгжлийн бодлогод уялдсан, тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх үйл явцыг нээлттэй хэлэлцдэггүй, ИТХ-д өргөн барихдаа хавсралтуудыг хүргүүлдэггүй дутагдал нийтлэг байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан журмын 5.10 дахь заалттай нийцэхгүй байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ, зураг төсвийг урьдчилан тооцоолоогүй баталжээ.

2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний 80 гаруй хувь нь зураг төсөв шаардагдахгүй арга хэмжээ байна.

ТЭЗҮ, зураг төсвийг урьдчилан тооцоогүй төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн сумдыг дурдвал:




- Түдэвтэй сумын наадмын талбай барих 18.2 сая төгрөгийн ажил
- Их-Ул сумын гүүр барих модны тусгаарлалтыг хийх 5.3 сая төгрөгийн ажил
- Отгон сумын тоглоомын талбайн хайс хийх 14.1 сая төгрөгийн ажил

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг ТЭЗҮ, хяналтын зураг, төсөвгүйгээр төлөвлөж, батлуулснаар тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилт хүрэлцэхгүйд хүрч, он дамжин удаашрах, нэмэлт санхүүжилт шаардагдах зэрэг эрсдэлийг үүсгэх магадлалтай байна.

Сумдын ОНХС-аар хэрэгжүүлж байгаа төсөл арга, хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ихэнх төсөл, хөтөлбөрийг шууд гэрээ байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 122 төсөл арга хэмжээний 16.3 хувийг нээлттэй тендер, 83.7 хувийг шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна. Өөрөөр хэлбэл 102 төсөл, арга хэмжээ нь 10.0 сая төгрөгөөс бага төсөвт өртөгтэй учир шууд гэрээ байгуулсан гэж үзэх үндэстэй байна.

График № 5



Дээрх графикаас харахад ихэнх ажлууд нь ШХА-ын аргаар зохион байгуулагдсан байна. Нийт хэрэгжих арга хэмжээний 40 гаруй хувь нь хэт жижиг, урсгал зардлын шинж чанартай байгаа нь сангийн “орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангасны үндсэн дээр иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин бүрдүүлэх” гэсэн зорилготой нийцэхгүй байна.

Аймаг, сумдын үнэлгээний хорооны гишүүд шууд гэрээ байгуулах, нээлттэй тендерээр гүйцэтгэгчийг сонгохдоо Сангийн сайдын баталсан тендерийн жишиг баримтын дагуу бичиг баримтаа боловсруулан хөтөлсөн байна.

Аймаг сумдын үнэлгээний хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу Засаг даргын захирамж гаргаж, ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажилласан байна.

Сумдын төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнүүд нь өөр өөр загвартай, 2 талын үүрэг хариуцлагыг тодорхой тусгаагүй, дутуу нөхсөн, нэмэлт гэрээний нөхцөл тусгагдаагүй байна. Иймд гэрээг Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, 2013 оны 39 дүгээр тушаалд заасан гэрээний маягтын дагуу хийх шаардлагатай байгаа талаар зөвлөмж өгч ажиллаа.

Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын чанартай төсөл, арга хэмжээнд ГХБХБГ хяналтыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалын 4 дүгээр зүйлд заасны дагуу аймагт хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд ГХБХБГ-аас хяналтыг хэрэгжүүлж байна.

Харин сумдын тухайд Засаг даргын захирамжаар байгуулагдсан тамгын газрын албан хаагчдаас бүрдсэн комисс захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна.

2017 оны хувьд санхүүжилт харьцангуй бага байгаагаас шалтгаалан томоохон хэмжээний төсөл хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлээгүй учир мэргэжлийн байгууллагын шаардлага гараагүй байна.

Ажлын хэсгийнхэн захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж, хүлээн авсан арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг актаар баталгаажуулжээ.

Ажил гүйцэтгэх гэрээнд санхүүжилтийн хуваарийг тусгаж, ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон байна.

ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулдаггүй дутагдал давтагдан гарсаар байна.

Тайлант хугацаанд аймгийн ОНХС-аар 23 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, 1,622.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Аймгийн ОНХС-ийн тухайд зориулалтын дагуу зарцуулсан боловч сумд зориулалтын дагуу зарцуулахгүй байна.

Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан сумдын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр:

Улиастай сум:

- Тэмцээн, уралдаанд дэмжлэг үзүүлэхэд 4.8 сая төгрөг
- Хаврын баяр наадам зохион байгуулахад 2.9 сая төгрөг
- Намрын ногоон өдрүүдийг зохион байгуулахад 1.0 сая төгрөг
- Улиастайн өдөр тэмдэглэхэд 0.5 сая төгрөг
- Нохой устгалд 3.0 сая төгрөг
- Ахмадын баяр тэмдэглэхэд 1.2 сая төгрөг
- Малчдын зөвлөгөөнд 1.0 сая төгрөг
- Нутгийн зөвлөлийн хүндэтгэлд 2.5 сая төгрөг
- Байгууллагуудын шагналд 2.4 сая төгрөг

Дөрвөлжин сум:

- Спорт урлагийн арга хэмжээнд 1.2 сая төгрөг
- Шинэ дөрвөлжин ОНӨҮГ байгуулахад 2.3 сая төгрөг
- Тамгын газрын урсгалд зардалд 4.0 сая төгрөг
- Нүүдэлчдийн соёлын наадамд 1.5 сая төгрөг
- Ахмадын баярт 0.5 сая төгрөг
- ИТХ-ын урсгал зардалд 2.5 сая төгрөг

Тосонцэнгэл сум:

- Үндэсний баяр наадамд Засгийн газраас тогтоосон хэмжээнээс илүү зарцуулсан 1.0 сая төгрөг
- Тамгын газрын урсгал засварт 10.5 сая төгрөг
- Тамгын газарт хөрөнгө худалдан авсан 10.7 сая төгрөг

Отгон сум:

- Үндэсний баяр наадамд Засгийн газраас тогтоосон хэмжээнээс илүү зарцуулсан 0.4 сая төгрөг
- Хаврын баярт 1.0 сая төгрөг
- Сумын Цагдаагийн тасагт драйгер худалдан авсан 1.7 сая төгрөг

Тэлмэн сум:

- Нүүдэлчдийн соёлын наадамд 5.0 сая төгрөг тус тус зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1, 60.3.3 дахь заалтуудтай нийцээгүй байна.

Иймд алдаа зөрчлийг дахин давтахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ОНХС-аас санхүүжүүлсэн арга хэмжээг бүртгэлд бүрэн тусгасан боловч, гэрээ хийлгүйгээр хувь хүмүүст эзэмшүүлсэн байна.

Төсөл хөтөлбөр, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комисс аймаг, сумдын Засаг даргын захирамжаар томилогдож зохих журмын дагуу акт үйлдэж ажилласан боловч хүлээн авахдаа тус тусын харьяалагдах байгууллагын бүртгэлд тусгах талаар дурдаж өгөөгүй байна.

Аудитын явцад бүртгэл болон өмчлөлтэй холбоотой дараах зөрчил илэрлээ.

- АОНХС-аар худалдан авсан 4 өрөө байрны ашиглагчтай гэрээ хийгээгүй.
- АОНХС-аар хэрэгжсэн сумдын худгийг хувь хүнд гэрээ хийлгүйгээр эзэмшүүлсэн
- Алдархаан суманд ОНХС-ийн хөрөнгөөр хувь айлын хашаанд байрлах худагт 5.0 сая төгрөгөөр засвар хийсэн./ нийтийн эзэмшилд хэрэглэх боломжгүй байна/

Аудитын явцад уг байрны ашиглагчтай гэрээ хийх, худгийн өмчлөлийг шийдвэрлэх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.3. Аймаг, сумдын ОНХС- аар хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр арга хэмжээнд тавих хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх болон тайлагнах үйл ажиллагаа хийгдэхгүй байна.

Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо ОНХС-аар хэрэгжсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний үр дүнд бүрэн хяналт тавьж, үнэлгээ хийгээгүй байна.

Аймаг болон сумдын ОНХС-ийн баримт материал, ажлын тайлангуудаас харахад Хяналтын хороо, Иргэний нийгмийн бүлгээс хяналт тавьсан үйл явц баримтаар нотлогдохгүй байна.

Дээрх байдал нь Сангийн сайдын 43 дугаар тушаалын “Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 9.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Цаашид ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын тайланг шат шатны ИТХ-аар хэлэлцэн холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Тайлант онд дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс хяналт тавьж ажиллаагүй байна.

Харин Сангийн яамнаас Тогтвортой амьжиргаа-3 төслийн хүрээнд 24 сумын ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт хийж холбогдох зөвлөмжүүдийг өгч ажилласан байна. ОНХС-ийн хөрөнгийг хуулийн хүрээнд төлөвлөж, үр дүнтэй зарцуулсан 4 сумд 97.0 сая төгрөгийн урамшуулал өгсөн байна.

Сумдаас орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн явцын тайланг АЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст тайлангаа ирүүлсэн боловч тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.

Аймгийн ЗДТГ нь ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилоогүй, Хөгжлийн бодлогын хэлтэс нь сумдаас ОНХС-ийн хэрэгжилтийн явцын тайланг хүлээн авах талаар ажил зохион байгуулаагүй байна.

Аймаг, сумд нь төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ “Шилэн дансны тухай” хуулийн шаардлагыг ханган ажилласан байна.

Аймаг, сумд нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2017 онд гүйцэтгэсэн төсөл арга хэмжээний санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг харьяалах Төсвийн ерөнхийлөн захирагч нарын цахим хуудсанд байршуулан ажиллажээ.

1.4. Төсвийн тухай хуулийг шинэчлэн найруулсантай холбоотой бусад журам, зааварт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Төсвийн тухай хуулийн 56.1, 59.2-т заасан ОНХС-ийн эх үүсвэрийн төрлүүд Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 6-д заасантай нийцэхгүй байна.

Төсвийн тухай хуульд заасан 58.2, 58.4 дэх заалтуудад тусгасан чиг үүргүүдтэй

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал болон батлагдсан “Орон нутгийн хөгжлийн заавар”-ийн 7.2 болон 7.4 заасан чиг үүргүүд уялдахгүй байна.

Иймд Төсвийн тухай хуульд нийцүүлэн холбогдох журмыг өөрчлөх шаардлагатай байна гэж үзлээ.

Цаашид сангийн үйл ажиллагааг үр дүнтэй болгохын тулд хяналтыг сайжруулах хэрэгтэй ба Захиалагчийн хяналтыг үр дүнтэй болгох талаар эрхзүйн зохицуулалт байхгүй нь сул талтай байна гэж үзлээ.

БҮЛЭГ 2. СХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл журамд заасан эрх үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

2.1 Сум хөгжүүлэх сангийн дансанд бусад хөрөнгө байршуулсан байна.

Сум хөгжүүлэх сан нь 2017 оны байдлаар нийт 5,966.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж байна. Эргэлтийн хөрөнгийг журамд тусгасан эх үүсвэр бүрээр нь судлан үзлээ. Үүнд:

➤ **Улсын төсвөөс олгох сум хөгжүүлэх сангийн эргэлтийн хөрөнгө:** Улсын төсвийн хөрөнгөөр 2011-2014 онд нийт 5,307.0 сая төгрөгийг олгосон байна.

Харин 2015 онд 130.0 сая төгрөгийн санхүүжилт олгосныг ҮАГ-аас төлбөрийн акт тогтоон буцаан төвлөрүүлсэн бөгөөд 2016, 2017 онуудад улсын төсвөөс санхүүжилт олгоогүй байна.

➤ **Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад дотоодын иргэн хуулийн этгээдийн хандив тусламж:** Уг эх үүсвэрээс орсон орлого байхгүй хэдий ч Засгийн газрын 2010 оны 197 дугаар тогтоолоор зудын улмаас амьжиргааны эх үүсвэрээ алдсан зарим малчин өрхийг малжуулах зориулалтаар эргэн төлөгдөх нөхцөлтэй, 3 жилийн хугацаатай 499.8 сая төгрөг олгогдсон бөгөөд зээлийн хугацаа дууссан байна.

Дээрх хөрөнгийг СХС-ийн дансанд төвлөрүүлж, сангийн хөрөнгийн эх үүсвэрт оруулан зээл олгож байх чиглэлийг сумдад хүргүүлсэн байна.

Эргэн төлөлтийн байдлыг судлан үзэхэд 213.5 сая төгрөгийг СХС-ийн дансанд төвлөрүүлж, 286.3 сая төгрөгийг арилжааны банк, орон нутгийн ерөнхий дансанд төвлөрүүлсэн, зарим хэсгийг малаар төлүүлсэн, зарим хэсгийг төлүүлээгүй байна.

Эргэн төлөлтийг хийгээгүй, арилжааны банк болон орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн 286.3 сая төгрөгийг СХС-д төвлөрүүлэх, арилжааны банкин дахь дансыг хаалгах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Ингэснээр СХС-ийн эргэлтийн хөрөнгө нэмэгдэж, ЖДҮ эрхлэгчид зээлд хамрагдах боломж нэмэгдэнэ гэж үзлээ.

➤ **Сангаас олгосон зээлийн хүүгийн орлого:** СХС-ийн үйл ажиллагааны хүрээнд нийт 2892 иргэнд 10,373.0 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд зээлийн хүүгийн орлогоор 442.7 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Зээлийн хүүгийн орлогыг төлөвлөж, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулан ажиллаагүй байна. Үүнийг зээлийн хүүгийн орлого бүрэн биелэх боломжгүй байдагтай холбоотой гэж тайлбарлаж байна. Учир нь тухайн зээлдэгч гэрээний хугацаанаас өмнө зээлээ төлсөн нөхцөлд хуримтлагдсан хүү боддоггүй, хугацаа хэтэрсэн зээлдэгчдээс үндсэн төлбөрөө авахыг урьдал болгож байгаа зэрэг нь нөлөөлж байна.

Зээлийн хүүг дараах байдлаар төвлөрүүлэхээр эргэн төлөлтийн хуваарь гаргасан байна. Үүнд:

- Хүүг жил бүр үндсэн зээлийн төлбөртэй хамт тэнцүү хэмжээгээр төлөх
- Үндсэн зээлийн төлөлтөөс хамааран хүүг бууруулах зарчмаар төлүүлэх
- Зээл олгосон тухайн үедээ хүүг суутгах
- Үндсэн зээл болон хүүг сар бүр тогтмол хэмжээтэй төлүүлэх
- Хугацаанаасаа өмнө зээлийг төлсөн иргэнийг зээлийн хүүгээс чөлөөлөх зэрэг олон арга, хэлбэрээр төвлөрүүлжээ.

СХС-ийн журамд зээлийн хүүг хэрхэн тооцож, төвлөрүүлэх талаар тодорхой заалт тусгагдаагүй учир зээлийн хүүг харилцан адилгүй тооцоолж, зээлийн эргэн төлөлтийн хуваарийг өөр өөр хэлбэрээр байгуулсан байна.

➤ **Хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги:** Зээлийн гэрээнд эргэн төлөгдөх хуваарийн дагуу төлөгдөөгүй буюу хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцохоор тусгасан байна. Гэтэл уг заалтын хэрэгжилт хангалтгүй байна. СХС-ийн алдангийн орлогоор 6.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Алданги тооцоход дараах бэрхшээлүүд тулгардаг байна.

- Хугацаа хэтрүүлсэн хоног тутамд зээлийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцоход алдангийн хэмжээ өндөр дүнтэй гардаг,

- Үндсэн зээлээ төлөхгүй байгаа болон зээлээ төлөх орлогын эх үүсвэргүй болсон зээлдэгч нарын хувьд хүндрэл болохоос гадна төлөгдөх найдваргүй авлага бий болох эрсдэл үүсэх


СХС-ийн дансанд дээрхэх үүсвэрээс гадна дараах орлогуудыг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Байгаль хамгаалах сангийн орлого
- Лицензийн төлбөр
- Орон нутгийн хэмжээнд байгуулсан зээл олгох сангийн хөрөнгө зэрэгтэй холбоотой 59.4 сая төгрөгийг байршуулсан байна.

Энэ нь СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын **1.4 “ Сангийн орлого, зарлагыг төрийн сан дахь тусгай дансаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг дансанд сангийн хөрөнгөнөөс бусад хөрөнгө байршуулахыг хориглоно”** гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд дээрх алдааг залруулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Эх үүсвэрийг графикаар харуулбал:



2.2 Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн мэдлэг чадвар дутмаг байна.

Төсөл сонгон шалгаруулалт:

СХС-ийн төсөл сонгон шалгаруулах товыг хөрөнгийн эх үүсвэрийн 20-оос доошгүй хувь нь бүрдсэн тохиолдолд сумын ИТХ-аас тогтоохоор журамд тусгасан байна. Энэ нь дунджаар 31.6-179.0 сая төгрөгийн хуримтлал бий болсны дараа зээлийг олгоно гэсэн үг юм.

Гэтэл сумдын эргэн төлөлтийн орлого удаашралтай байгаагаас хуримтлал үүсэхээс өмнө төсөл сонгон шалгаруулж, зээл олгож байна.

Ихэнх сум төсөл сонгон шалгаруулах комиссыг шинэчлэн байгуулж, төсөл хүлээн авч хэлэлцэн, зээл олгож байгаа хэдий ч шаардлага хангасан төсөл шалгаруулсан нь ховор байна.

Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлж байна гэж үзлээ.

- ❖ Зөвлөлийн гишүүдийн ЖДҮ-ийн талаарх туршлага, мэдлэг, ур чадвар дутмаг. Зөвлөлийн гишүүнд орж ажиллах багийн төлөөллийг сонгохдоо багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлдэггүй, тухайн төслийн үр

ашгийн тооцоо, гарах үр дүнг тооцоолох мэдлэг ур чадвартай эсэхийг харгалзан үздэггүй,

- ❖ Алслагдсан болон аймгийн төвтэй ойрхон сумдад ЖДҮ хөгжих зах зээл бүрдээгүй байдал. ЖДҮ болон өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор зээл олгоход тухайн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авах хэрэглэгч байдаггүй, өөр бусад аймаг, сум руу тээвэрлэн борлуулахад ашиг олох магадлал нь бага учир зээлийн хэрэгжилт үр дүнгүй болох тохиолдлууд гардаг байна.
- ❖ Иргэдийн дундах буруу ойлголт: өмнөх онуудын зээлийн эргэн төлөлт удаашралтай, зээлийн хэрэгжилт хангалтгүй, зориулалт бус зарцуулалт зэрэг нь сөрөг хандлагыг бий болгож байна.

Зээлийн гэрээний хэрэгжилт:

Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн шалгарсан төслүүдийг сумдын Засаг даргын захирамжаар баталгаажуулан иргэн, хуулийн этгээдтэй зээлийн болон барьцааны гэрээ байгуулан ажиллажээ.

Зээлийн гэрээний дараах заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.

- Нэмэгдүүлсэн хүү буюу зээл, хүүгийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөөгүй зээлд хоног тутамд 0,5 хувиар алданги тооцох,
- Гэрээнд заасан төслийн дагуу үйл ажиллагаагаа эрхлээгүй, зориулалтын бус ашигласан тохиолдолд зээлийн хүүг нэмэгдүүлсэн хүүд шилжүүлэх,
- Зээлдэгч авсан зээлээ хуваарийн дагуу төлөөгүй бол зээлдүүлэгч эхний ээлжид бодогдсон хүүг бүрэн төлүүлсний дараа зээлийн үндсэн өрийг барагдуулах,
- Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан хохирол, зардлыг бүрэн төлнө,
- Зээлдэгч зээлийн төлбөрийг төлбөрийн хуваарийн дагуу төлнө,
- Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээлдүүлэгч гэрээг цуцалж, зээл, хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг үл маргах журмаар төлүүлнэ гэсэн заалтууд байна.

Барьцааны гэрээнд хашаа байшин, тээврийн хэрэгсэл, цахилгаан бараа, мал зэргийг барьцаалахаар тусгасан ч, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг эх хувиар нь авч хадгалаагүй, хуулбарыг нь хавсаргасан байгаа нь шаардлага хангахгүй байна. Учир нь СХС-ийн зээлийн барьцааны хөрөнгө банк болон бусад зээлийн барьцаатай давхарддаг байна.

Мөн нөгөө талаас барьцааны хөрөнгийн гэрчилгээний эх хувийг хадгалах орчин нөхцөл бүрдээгүй байна гэж үзлээ.

СХС-ийн хөрөнгийг төсөл хөтөлбөрт зээл олгох, зээлийн хэрэгжилтэд хяналт тавих, сургалт зохион байгуулах ажилд зарцуулахаар журамлажээ.

Зээл олголт :

СХС-ийн зээлийг олгож эхэлснээс хойш /2011-2017 онуудад/ нийт 2892 иргэнд 10,373.0 сая төгрөгийн зээл олгожээ.

2017 оны жилийн эцсийн байдлаар 5,055.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байна. Үүнээс хэвийн төлөлттэй 2,332.1 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 2,493.7 сая төгрөг, төлөгдөх найдваргүй буюу чанаргүй 229.9 сая төгрөгийн зээл байна.

Чанаргүй зээлд эргэн төлөгдөх найдваргүй буюу холбогдох эзэн нь нас барсан, хаяг нь тодорхой бус, шилжсэн болон бусад үндэслэлээр шүүх хүлээн авах боломжгүй зээлийг хамруулсан болно.

Зээлийн үлдэгдлийг графикаар харуулбал:



Зээлийн эргэн төлөлт удаашралтай байгаад дараах хүчин зүйлс нөлөөлж байна гэж үзлээ.

- Төрийн албаны тогтвортой бус байдлаас тухайн албан тушаалын албан хаагч ойр ойрхон солигддог,
- Албан хаагч солигдохдоо өмнө нь ажиллаж байсан албан хаагчаас ажил хүлээлцдэггүй, ажил хүлээлцэхдээ хайнга ханддаг байдал,
- Шинээр томилогдсон сумын удирдлагууд өмнөх удирдлагын олгосон зээлийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй,
- Зээлийн хэмжээг хэтэрхий бага олгосноор төсөл хэрэгжих боломжгүй байдалд хүрч, зээлийн эрсдэлд орж байна,
- Хэрэгжих боломжгүй төсөлд зээл олгосноос тухайн зээлдэгч зээлийг эргэн төлөх чадваргүй болж, эрсдэлд ордог байна.

Хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг шүүхийн байгууллагад шилжүүлэхэд дараах хүндрэл бэрхшээл учирч байна.

- ✚ СХС-ийн зээлийг анх олгохдоо барьцаа хөрөнгөгүй, хамтран зээлдэгчгүй олгосон,
- ✚ Зээлд хамрагдсан зарим иргэд шилжсэн,
- ✚ Хаяг нь тодорхой бус,
- ✚ Нас барсан,
- ✚ Шүүхийн зардлыг СХС-аас төлүүлдэг,
- ✚ Хугацаа их алддаг байна.

СХС-ийн зээлд хамрагдсан иргэдийн ажлын байрыг судлан үзэхэд өрхийн үйлдвэрлэл буюу хатуу зөөлөн оёдол, сүү цагаан идээний үйлдвэрлэл ихэнх хувийг эзэлж байгаа нь аудитын явцад ажиглагдлаа.

Зээлд хамрагдсан иргэдийн ажлын байрны тогтвортой байдлыг судлан үзэхэд 2892 иргэний 1871 иргэн тогтмол үйл ажиллагаа явуулж байна.



Графикаар харуулбал:



Үүнээс харахад СХС-ийн зээл үр дүн багатай байгаа нь харагдаж байна.



СХС-ийн төслийн хүрээнд 4355 ажлын байр бий болсон бөгөөд үүнээс шинээр 2651 ажлын байр бий болж, 1704 ажлын байр хадгалагдсан гэсэн тоон мэдээ байна.

2017 онд 344 иргэнд 1,285.7 сая төгрөгийн зээл олгосон байна. Зээл олголтыг судлан үзэхэд дараах зөрчил илэрлээ.

- СХС-ийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдэд өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэн байгуулаагүй, төсөлд зээл олгохдоо төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөр хэлэлцүүлэлгүй Нөмрөг сумын засаг дарга дур мэдэн 24 иргэнд 56.5 сая төгрөг, Алдархаан сумын засаг дарга / 2018 онд засаг даргын албан тушаалаас чөлөөлөгдсөн/ 8 иргэнд 7.5 сая төгрөг олгосон,
- Түдэвтэй сум нь засаг даргын шийдвэргүй 20 иргэнд 47.0 сая төгрөг олгосон,
- Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлээгүйтэй холбоотой 36.2 сая төгрөг байна.
- Зээлд хамрагдсан иргэнтэй гэрээ байгуулаагүй 14.0 сая төгрөг

Төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөр хэлэлцүүлэлгүй зээл олгосон Нөмрөг сумын засаг даргад хариуцлага ногдуулах, зээлд хамрагдсан иргэнтэй гэрээ байгуулаагүй Тэс, Улиастай сумдад алдааг залруулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Сангийн бусад зарцуулалт:

2017 онд нийт 68.3 сая төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнийг 26.8 хувь буюу 18.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнийг задлан харвал дараах байдалтай байна.

- Зээлийн хэрэгжилтэд хяналт тавих болон төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой бичиг хэрэг, шуудан холбоо, тээвэр шатахуун, хоолны зардалд 10.8 сая төгрөг,
- Шүүхийн ажиллагааны зардал 1.8 сая төгрөг,
- Хөрөнгө бэлтгэсэн 4.6 сая төгрөг,
- Баяр наадмын зардлыг санхүүжүүлсэн 1,0 сая төгрөг,

- Бусад зардалд -0.1 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Зээлийн хүүгийн орлогыг зориулалт бус зарцуулж баяр наадмын үйл ажиллагааг санхүүжүүлсэн Идэр сумын 1,0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

СХС-ийн өмнөх онуудын зарцуулалтыг судлан үзэхэд дараах нийтлэг алдаанууд байна.

- Хөрөнгө бэлтгэсэн,
- Төсөл сонгон шалгаруулах зөвлөл болон зээлийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгосон,
- Гэрээт ажилтан авч цалинжуулсан,
- СХС-ийн зээлд хамрагдсан иргэдийн ажлын байрны түрээсийн төлбөр төлсөн,
- Томилт, унааны зардал олгосон,
- ОНХС болон бусад төсөл арга хэмжээний зардлыг түр санхүүжүүлсэн зөрчил байна.

Дээрх алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.3 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

Эрх үүргийн хэрэгжилт:

Аймгийн засаг дарга: Сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг тухайн аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын тамгын газрын жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан нэгж болох Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс хариуцан ажиллахаар журамд тусгагдсан ч өнөөдрийн байдлаар зөвхөн хүнс хөдөө аж ахуйн газрын нэгтгэсэн мэдээ тайланг хүлээн авахаас өөрөөр СХС-ийн үйл ажиллагаанд оролцохгүй байна.

Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, түүнд чиглэсэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал: Сумын ИТХ-ын хэрэгжүүлэх чиг үүргүүдээс дараах ажлын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзлээ.

1. Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн зохих журмын дагуу шийдвэрлэх.
 - ✓ СХС-ийн зээлийн хэрэгжилтэд хяналт тавих хяналтын зөвлөлийг сум бүр журмын дагуу байгуулсан ч хяналтын зөвлөл нь зээлийн эргэн төлөлтөд ямар нэгэн байдлаар оролцох оролцоогүй, бэлгэдлийн чанартай байна. Уг хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайлантай танилцахад ямар ч хяналт тавьсан ажил байхгүй, зарим гишүүд нь хяналтын зөвлөлд орсон гэдгээ мэдэхгүй байлаа. Цаашид ИТХ хяналт тавих зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, арга зүйгээр ханган дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.
 - ✓ СХС-ийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг хэлэлцдэг хэдий ч хүүгийн орлогын төлөвлөгөө, зарцуулалтыг батлаагүй, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга зүйгээр ханган ажилласан бодитой шийдвэр гаргаагүй байна.
2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлүүдийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн

төлөөллийг томилохдоо багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлээгүй байна.

Сумын засаг дарга: Сумын засаг даргын хэрэгжүүлэх ажлуудаас иргэдийн оролцоог хангаж ажиллах, иргэдийн дунд сургалт зохион байгуулах ажил хийгдээгүй байна.

СХС-ийн зээлийн эргэн төлөлтөд тухайн санг хариуцсан албан тушаалтнаас өөр хяналт тавьж байгаа байгууллага, албан тушаалтан байхгүй байна.

СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл: Уг зөвлөл нь сангийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих эрх, үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Сангийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөлийн гишүүд эрх, үүргээбүрэн хэрэгжүүлж, ажлын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн ажилладаг байх шаардлагатай байна.

СХС-ийн хөрөнгийн бүртгэл тайлагнал:

СХС-ийн орлого зарлагын гүйцэтгэлийн тайланг жил бүр төрийн аудитын байгууллагад хүргүүлэн баталгаажуулалт хийлгэсэн байна.

Мөн сумд сангийн орлого зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал бүр гарган ЖДҮ-ийн хариуцсан нэгжид хүргүүлэхээр журамд тусгагдсан ч хагас бүтэн жилээр мэдээ тайланг гарган хүргүүлсэн байна. Энэ нь СХС-ийн сангийн төсөл болон бүрдүүлэх баримт материал, мэдээ тайланг мал үржлийн тасгийн мэргэжилтэн хариуцаж байхад орлого, зарлагын тайланг өөр албан тушаалтан хариуцаж байгаатай холбоотой байна гэж үзлээ. Өөрөөр хэлбэл 2 хүний дунд ажил цалгардах хандлага ажиглагдаж байна.

СХС-ийн үйл ажиллагааг сум бүрд өөр өөр албан тушаалын хүмүүс хариуцаж байна. Үүнд:

- Мал үржлийн тасгийн дарга
- Мал үржлийн тасгийн мэргэжилтэн
- Санхүүгийн албаны дарга
- Тамгын газрын нягтлан бодогч гэх мэт байна.

СХС-ийн үйл ажиллагааг нэг хүнд хариуцуулан, тогтвортой байлгах шаардлагатай байна гэж үзлээ.

Мэдээ тайлангийн гаргалтыг судлан үзэхэд СХС-н зээлийн бодит үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй, хүүгийн авлагыг үндсэн төлбөрийн авлагын дүнд оруулсан, зарим сумд тайланд тусгаагүй зэрэг 227.1 сая төгрөгийн нийтлэг алдаа байгаад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Хариуцлага тооцсон байдал

Зээлийг гэрээний хугацаанд төлөөгүй, зориулалтын дагуу зарцуулаагүй иргэн, хуулийн этгээдэд хариуцлага тооцсон зүйл байхгүй байна.

Төрийн аудитын газрын санхүүгийн аудитаас өөр СХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөмж өгсөн байгууллага, албан тушаалтан байхгүй байна.

2.4 Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зорилго, зорилт алдагдах эрсдэл бий болсон байна.

СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам нь бусад хууль эрх зүйн актуудтай зөрчилдсөн нөхцөл байдал үүсээгүй байна.

Аудитын явцад сумдын удирдлага, СХС хариуцсан албан тушаалтан, төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд, хяналт тавих зөвлөлийн гишүүдтэй уулзалт ярилцлага хийхэд сангийн үйл ажиллагаа үр дүн муутай, төсөл хөтөлбөрүүд хэрэгжихгүй, тухайн сангийн мөнгө хүү багатай зээлийн хэлбэрт шилжсэн, тухайн үед мөнгө хэрэгтэй хүний хэрэгцээг хангах төлбөрийн хэрэгсэл болсон гэсэн санаанууд давхардан гарч байгаагаас үзэхэд СХС-ийн зориулалт алдагдаж, төсвийн хөрөнгө үрэлгэн зарцуулагдах эрсдэл үүссэн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Дээрх нөхцөл байдал үүсэж байгаа нь сумдад ЖДҮ хөгжих нөхцөлбайдал хомс, СХС-аас иргэн, хуулийн этгээдэд олгох зээлийн хэмжээ бага,СХС-ийн эргэлтийн хөрөнгө их байгаатай холбоотой байна.

Иймд СХС-ийн эргэлтийн хөрөнгийн тодорхой хэсгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, ЖДҮ эрхлэгчдэд олгох зээлийн доод хэмжээг тогтоож,СХС-ийн хөрөнгийн зээл олголт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй байна. Ингэж жижиг зээл олгох байдлыг зохицуулснаар дээрх үр дүнгүй нөхцөл байдлууд багасах боломжтой гэж үзлээ.

СХС-ийн аудитаар нийт 456.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

БҮЛЭГ 3. ОНХС-ийн өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 85% -аар хэрэгжжээ.

3.1 ОНХС-ийн актын төлбөрийн барагдуулалт 100 хувь биелсэн байна.

ОНХС-ийн өмнөх аудитаар 785.7 сая төгрөгийн зөрчил, 288.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 33 заалт зөвлөмж хүргүүлсэн байна.

Актын төлбөрийн барагдалт 100 хувьтай байна.

Албан шаардлагын биелэлт 85%-тайбайна. Өмнөх оны аудитаар 210.4 төгрөгийн зөрчилд 7 ширхэг албан шаардлага хүргүүлэн ажилласан байна.

Албан шаардлагын хэрэгжилтийн байдлыг үзэхэд Сонгино суманд өгөгдсөн Хадлан хадах, өвс бэлтгэх, тэжээлийн ургамал тарих тоног төхөөрөмж нийлүүлэх ажил дутуу хэрэгжин дагалдан сэлбэг хэрэгсэл дутуу нийлүүлэгдсэн, Яруу сумын

эрүүл мэндийн төвд биохими, шээсний аппарат нийлүүлэгдэх 10.5 сая төгрөгийн ажил огт хэрэгжээгүй байна.

Тодруулахад Яруу сум нь аймгийн аудитын газарт 2017.06.19-ний өдрийн А/95 тоотор гүйцэтгэгчид 1.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу байгаа тул бүтээгдэхүүн нийлүүлэгдээгүй, 2017 оны санхүүжилтээс үлдсэн төлбөрийг төлөх хүртэл түр хойшлуулахыг хүссэн байна.

Гэтэл 2017 оны санхүүжилтээс төлбөрийн дутуу хийгээгүй тул уг албан шаардлага хэрэгжээгүй байна.

Зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байгаа боловч урьд жилийн зөвлөмжөөр өгөгдсөн алдааг биелүүлээгүй зарим сум байна.

Тухайлбал: Аймаг болон Улиастай, Дөрвөлжин, Тосонцэнгэл зэрэг сумдад ОНХС-аас аймаг, сумын удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг санхүүжүүлэхгүй байх, зориулалт бусаар санхүүжүүлэхгүй байх гэсэн зөвлөмж өгөгдөж, биелэлт нь 100 хувиар ирсэн боловч дээрх алдаа дахин давтагдлаа.

Аудитаар нийт 669.4 сая төгрөгийн зөрчил илэрч, 6.3 төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

3.2 СХС-ийн зарцуулалтад хийсэн өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 68,8 хувьтай байна.

СХС-ийн үйл ажиллагаанд өмнөх онуудад гүйцэтгэл, нийцлийн аудит хийгээгүй бөгөөд 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх аудитаар 2065.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулахаар 24 суманд албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Хэрэгжилтийг авч үзэхэд 334.1 сая төгрөгийг дансанд төвлөрүүлж, 1016.5 сая төгрөгийг Шүүхийн байгууллагад шилжүүлж, 589.3 сая төгрөгийг шүүхийн шийдвэр гаргуулан, 17.7 сая төгрөгийн зээлийг бүрэн төлүүлж, 44.9 сая төгрөгийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж буцаасан, 7.0 сая төгрөгтэд хөрөнгийн зүйл авчээ. Албан шаардлагын хэрэгжилт 68.8%-тай байна.

СХС-ийн зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн системд оруулснаар зээлд хамрагдсан иргэдийн зээл төлөлт идэвхижсэн байна.

Санал асуулгын талаар:

Аудитын явцад нийт 17 сумыг хамруулан 301 ЖДҮ эрхлэгч иргэдээс санал асуулга авсан байна. Үүнээс үйлдвэрлэл эрхлэгч 56, үйлчилгээ явуулдаг 117, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 131 иргэн хамрагдсан байна.

Судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдсан иргэдийн 65.8 хувь нь СХС-ийн талаарх мэдээлэл хангалтгүй, 75.8 хувь нь СХС-ийн үйл ажиллагааны үр дүнг хангалтгүй, мэдэхгүй гэж үнэлсэн байна.

СХС нь үр дүнгээ өгч байна уу гэсэн асуултад хангалтгүй, үр дүн муутай гэсэн үнэлгээг 35.3 хувь нь өгсөн байна. Дээрх асуудалтай холбоотой ЖДҮ эрхлэгч иргэдээс дараах саналууд давхардан гарсан байна. Үүнд:

- Нүдээ олж өгөх шаардлагатай байна.
- ЖДҮ эрхлэгч нарт олгох хэрэгтэй
- МСҮТ төгссөн хүүхдүүдэд өгөх
- Ард иргэдэд тайлангаа тавьж байх
- Зээл авсан иргэд сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулдаг
- Зээлийн хэмжээ бага учир үр дүнд хүрдэггүй гэсэн саналуудыг өгсөн байна.

СХС-аас зээл авахад хүндрэл бэрхшээл байсан уу гэсэн асуултад дараах саналуудыг ирүүлсэн байна. Үүнд:

- Өмнөх зээлийн эргэн төлөлт ордоггүйгээс зээл авахад цаг алддаг
- Сангийн мөнгө дууссан гэж төсөл олгоггүй удаадаг
- Хэзээ, хаана, хэнд өгч байгаа нь тодорхой бус байдаг
- Бүрдүүлэх материал ихтэй
- Барьцаа хөрөнгө шаарддаг
- Нам хардаг
- Танил тал хардаг
- Шинээр ажил эхлэхэд санхүүжилт олддоггүй
- Олгож байгаа зээлийн хэмжээ бага байдаг
- Удирдлагууд шууд шийдвэр гаргадаг гэсэн саналууд давхардан гарсан байна.

ДҮГНЭЛТ: ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх нийцлийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүд нь урсгал зардлын шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь сангийн үйл ажиллагааны зорилго, зорилтод нөлөөлж байна. Иймд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг боловсруулахдаа орон нутгийн хөгжилд нөлөөлөх байдлаар зөв эрэмбэлэх шаардлагатай байна.
2. Мөн Үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөрт тусгасан хөтөлбөр, арга хэмжээний эх үүсвэрт ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 60.3 болон Сангийн сайдын 43 дугаар журамд заасан чиг үүргүүдэд нийцүүлэх шаардлагатай байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлд шат, шатны хяналтыг сайжруулан үр дүнг хэлэлцэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ: СХС-ийн үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх нийцлийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Хүүгийн орлогыг зээлийн эргэн төлөлтийн гэрээний дагуу төлөвлөж, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах, биелэлтийг тооцож ажиллах
- СХС-ийн зээлийн ашиглалт, эргэн төлөлт, зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулан ажиллах нь зүйтэй байна.
- Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах шаардлагатай байна.
- ЖДҮ эрхлэгч иргэдийг сургалтад хамруулж, СХС-ийн зээлийн хөрөнгийн талаарх мэдлэгийг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.
- СХС-ийн тайланг иргэд олон нийтэд мэдээлэх, түгээх асуудал дутмаг байна.


Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн саналыг аудитын тайланд тусгасан байдал:

ОНХС, СХС-ийн аудитын тайлан, зөвлөмж, илэрсэн зөрчил төлбөртэй холбоотой дараах санал ирүүлсэн байна.

Ирүүлсэн саналыг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, гарсан шийдвэрт үндэслэн аудитын тайланд дараах байдлаар тусгалаа:

1. Ирүүлсэн саналыг үндэслэн аудитын тайлангийн 1.1, 1.2.1.1, 1.2.2.1, 1.2.2, 1.3.2.1 дэх зорилтуудын утга найруулгын алдааг засаж. 1.3.2.1 дэх заалтад тодруулга хийлээ.

2. Улиастай сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Прокурорын албан хаагчдад хувцас худалдан авч өгсөн 0,8 сая төгрөгийн актын төлбөрөөс чөлөөлж, албан шаардлагаар дахин зөрчлийг давтахгүй байх арга хэмжээг авч ажиллах.



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
81000 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: zavkhan.gov.mn@gmail.com

2018.11.30 № 6/1295
Танай _____ -ны № _____ Т

Тайлбар өгөх тухай

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

ОНХС-агаар хийж хэрэгжүүлэх ажлыг ОНХС-ийн журмын 7 дугаар заалтад заасан ажил арга хэмжээг санхүүжүүлсэн. 2017 оны хувьд АОНХС-д 1,4 тэрбум төгрөг хуваарилагдсанаас сумдад 435,3 сая төгрөг дунджаар 18,1 сая төгрөг нэг суманд төлөвлөгдсөн. Үүнээс сум Улсын баяр наадам зохион байгуулах ажилд 5,0 сая төгрөг зарцуулан, хамгийн багадаа 2-4 ажил арга хэмжээнд зарцуулахад ТБОНӨХБАҮХАТХ-ийн /7,3 дахь заалт/ босго үнийн түвшинд хүрэхгүй байгаа нь хэт жижиглэсэн ажил мэт харагдаж байгаа болно. /1.2.1.1/

Сумдын ЗДТГ болон тухайн жилийн үндсэн чиглэл боловсруулах ажлын хэсэгт ОНХС-ийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлж болох /ТТХуулийн 60,3-д заасан/ ажлын жагсаалтын хүргүүлсэн тул энэ төрлийн зөрчил давтан гарахгүй гэдэгт итгэж байна.

Завхан аймаг нь "Ард иргэдээ сонсох аян"-г 2016 оны 10-р сард 24 сумын хэмжээнд зохион байгуулж 8800 иргэдээс санал авч эрэмбэлэн гарсан саналыг сумдад хүргүүлсэн. Дээрх аяны хүрээнд 2017 онд 11,000 иргэд, 2018 онд 13,000 иргэдээс санал аван эрэмбэлээд байна. /1.2.1.2/


2017 оны хувьд АОНХС-д 1,7 тэрбум төгрөг байгаагаас сумдад дунджаар 18,1 сая төгрөг хуваарилагдсан болно. Үүнээс сум Улсын баяр наадам зохион байгуулах ажилд 5,0 сая төгрөг зарцуулахаар үлдэж буй нь тухайн сумыг бусад /2-4/ ажил арга хэмжээнд зарцуулахад ТБОНӨХБАҮХАТХ-ийн /7,3 дахь заалт/ босго үнийн түвшинд хүрэхгүй юм. Тиймээс шууд гэрээ байгуулан ажилласан байна. /1.2.2.1/

Сум хөгжүүлэх сангийн хувьд зориулалт бусаар ашиглахгүй байхыг аймаг сумдын хувьд ажлын хэсэг гарган ажиллуулж заавар зөвлөгөө өгч ажиллах болно. Цаашид Зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүрэн хамруулах шаардлагатай байгааг та бүхэнд уламжилж байна.//

6,3 сая төгрөгийн төлбөрийн акттай танилцлаа. Монгол улсын ЗЗНДНТХуулийн 29.1.6.д, Прокурорын тухай хуулийн 59,7 дахь заалтыг үндэслэн тус байгууллагад дэмжлэг үзүүлсэн. Тиймээс энэхүү актыг хүлээн зөвшөөрөх боломжгүй тул хасч өгөхийг хүсье.

Хүндэтгэсэн

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГОВ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Ж.БАТЦЭНГЭЛ



Doc tool document

000 10900

ЗӨВЛӨМЖ

Аймгийн засаг дарга Д.Батсайханд

Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. АОНХС-аар хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлагдсан жагсаалтаас бусад төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тухайн онд төлөвлөж, ажлын гүйцэтгэл баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэн өр авлага үүсгэхгүй байх.
2. Засаг даргын мөрийн хөтөлбөр болон үндсэн чиглэлд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний эх үүсвэрийг тусгахдаа, Төсвийн тухай хуулийн 60.3.6 дахь заалт болон Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан журмын 7.2-д заасан чиг үүргүүдээс бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхгүй байх.
3. Сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн явц болон бүтэн жилийн тайланг журамд заасан хугацаанд авч тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг тайлагнах үүрэг бүхий ажлын хэсгийг томилон ажиллуулах.
4. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж, хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л. УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

**Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга
н.Батцэнгэлд**

Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. АОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 4 дэх бүлэгт заасан заалтуудыг баримталж ажиллах.
2. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг 7 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор хүлээн авч, хэрэгжилтийн үр дүнд шинжилгээ хийж, санал зөвлөмжийг сум бүрээр гарган аймгийн Засаг даргад танилцуулж хэвших.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л. УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

Сумдын Засаг дарга нарт

Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг төлөвлөхдөө Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан зааврын 4.1-д заасан зарчмуудыг баримтлан ажиллах
2. Гүйцэтгэгчтэй хийх гэрээг сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаал, 2013 оны 39 дүгээр тушаалын дагуу гэрээний загварын дагуу хийж гарын үсгээр бүрэн баталгаажуулан ажиллах, гэрээний загварт алданги, торгуулийн дээд, доод хязгаар, гүйцэтгэгч байгууллагын үүрэг хариуцлагыг тодорхой тусгаж байх.
3. ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бус зарцуулах буюу удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг санхүүжүүлдэг дутагдлыг дахин давтахгүй байх.
4. Сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэний төлөөллөөр хяналтыг хийлгэж, хяналтын тайланг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж байх.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын тайлан, хэрэгжилтийн явцын тайлан журамд заасан хугацаанд Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт хэлтэст хүргүүлж хэвших.
6. Сум хөгжүүлэх сангийн хүүгийн орлогын төлөвлөгөө, түүний зарцуулалтыг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж байх
7. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг журмын дагуу ажиллуулах
8. Сум хөгжүүлэх сангийн дансанд бусад орлого төвлөрүүлэхгүй байх,
9. Малжуулахын зээлийн төлөгдөөгүй үлдэгдлийг барагдуулж, СХС-ийн дансанд төвлөрүүлэн, СХС-ийн тайлан мэдээнд оруулж байх
10. Сангийн тайлан мэдээг үнэн зөв гаргаж, авлагыг үндсэн төлбөр, хүүгийн авлагаар салгаж тайлагнах,
11. Сум хөгжүүлэх сангийн хүүгийн орлогыг зориулалтын дагуу зарцуулж байх
12. Сангийн эх үүсвэрийн 20%-аас дээш орлого бүрдсэний дараа төсөл сонгон шалгаруулж, зээл олгож байх
13. СХС-ийн зээл олголт, түүний хэрэгжилтийн талаар олон нийтэд мэдээлж байх

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л. УЛАМБАЯР

